

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№ Т-24/01

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”) 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ерөнхий Сайд Амарын Гудамж-15 тоот хаягт байрлах Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал (Best Western Premier Tuushin Hotel)-ын 5 давхрын “Соёмбо” танхимд зохион байгуулагдав.

**ХЭЭХ-д оролцсон албан тушаалтнууд:**

- ХЭЭХ-ын дарга: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дарга О.Болдбаатар,
- Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн: С.Боргил,
- ХЭЭХ-ын Тооллогын комиссын дарга, “Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН-ийн партнер С.Батбуян,
- ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга: Компанийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргал,
- Хараат бус аудитор: “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийн төлөөлөл
- Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд нар оролцож, ХЭЭХ-ыг хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хөтлөн явуулав.

**ХЭЭХ-ын ирц:** Нийт саналын эрх бүхий хувьцааны **81.7%**

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болсон байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя. “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар; “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр; “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн С.Боргил, Тооллогын комиссын дарга “Өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛекс ХХН”-ийн Партнер С.Батбуян; “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийн төлөөлөл, “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд; “ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал, Хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал миний бие тус тус оролцож байна.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу Хурлын ирцийг мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга С.Батбуян таныг индэрт урьж байна.

**Тооллогын комиссын дарга С.Батбуян :**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид маань хурлын танхимд хүрэлцэн ирж <https://survey.lend.mn/> цахим хуудаст хандаж саналаа өгөх нэвтрэх нэр, нууц үг авснаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч нарын ирцийг бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч та бүхэнд ирц бүртгүүлэхэд олгосон мандатад буй QR кодыг уншуулан <https://survey.lend.mn/> цахим хуудсанд өөрийн гар утас болон компаниас бэлтгэсэн компьютер ашиглан саналаа өгөх боломжтой. Та саналаа урьдчилан өгөх боломжтойгоос гадна ХЭЭХ-аар хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулж, асуулт, хариулт, хэлэлцүүлэг явагдсаны дараа <https://survey.lend.mn/> цахим хуудсаар санал хураалт явагдана. Хэрэв саналаа урьдчилан өгсөн бол энэ хэсэгт дахин санал өгөх боломжгүй. ХЭЭХ-ын дэгийн дагуу санал хураалтын хугацаа дуусахад санал хураалтын цахим хуудас хаагдах тул үүнээс хойш санал өгөх боломжгүй болох ба та санал өгөх системд саналаа бүрэн гүйцэд, зөв бөглөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу саналын хуудас хүчингүйд тооцогдоно гэдгийг та бүхэн анхаараарай.

Ингээд та бүхэнд “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчид маань 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 18:00 цаг хүртэл брокер, диллерийн компаниудаар дамжуулан санал өгөх боломжтой байсан. Шалгаж үзэхэд ийнхүү ирүүлсэн санал гараагүй тул хурлын ирцэд тооцох санал байхгүй болохыг тэмдэглэж байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий хувьцааны 81.7 хувийг эзэмшиж байгаа 66 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж бүртгүүлсэн байх тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдэж, ХЭЭХ хүчин төгөлдөр болж байгааг хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

#### **ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Тооллогын комиссын дарга С.Батбуяндаа баярлалаа.

Одоо та бүхний өмнө “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-н дарга, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар таныг Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулна уу хэмээн индэрт урьж байна.

#### **ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:**

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Компанийн нийт хамт олны өмнөөс хүргэе.

2023 он “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд бизнесийн өндөр өсөлтийг үзүүлсэн жил байлаа. Тус оны онцлох үйл явдлаас товч дурдвал:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу финтек зээл олгож буй байгууллагууд нь тухайн финтек зээлийн бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, бүртгүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд тус журамд заасан шаардлагуудыг бүрэн хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр LendMN аппликейшныг холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан гэж дүгнэж, LendMN аппликейшнээр олгож буй финтек зээлийн бүтээгдэхүүнүүдийг албан ёсоор бүртгэлээ.
2. Бид 2023 онд харилцагч нарт ээлтэй, уян хатан нөхцөлтэй “Flexi” шинэ финтек зээлийн бүтээгдэхүүнийг санхүүгийн зах зээлд амжилттай нэвтрүүлээ. Цаашид “ЛэндМН ББСБ” ХК нь Flexi зээлийг жижиг, дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нарт зориулан санал болгож, тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

зорилгоор 100 хувь цахимаар олгох “Flexi Business” зээлийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

3. ЛэндМН нь 2023 оны 10 дугаар сарын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг бүрэн буюу 98.6% ханган ажиллалаа.
4. Монгол улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй баялаг бүтээгчдээс тухайн жилийн салбарын шилдгүүд болон манлайлагчдыг тодруулж олон нийтэд төдийгүй олон улсын түвшинд таниулан сурталчлах зорилготой “Bloomberg Awards 2023” арга хэмжээний “Шилдэг Өсөлт” номинацийн эзнээр “ЛэндМН Банк Бус Санхүүгийн Байгууллага” Хувьцаат компани шалгарлаа. Мөн Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос зохион байгуулдаг хөрөнгийн зах зээлийн шилдгийг шалгаруулдаг “Grand Bull Awards 2023” арга хэмжээний “Шилдэг нээлттэй хувьцаат компани”-ийн нэгээр шалгарлаа.
5. 2023 онд гэрээт харилцагчдын тоо өмнөх жилээс 4.1%, олгосон зээлийн тоо 25.2%, олгосон зээлийн дүн 77.4%, зээлийн багц 76.4%-иар тус тус өссөн байна. Энэ өсөлт нь манай компанийн зээлийн үйл ажиллагаа улам бүр тэлж байгааг илэрхийлэх бөгөөд зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр 7 жилийн түүхэнд хамгийн дээд хэмжээнд хүрсэн амжилттайгаар ажиллалаа. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хурлаас компанийн нэгж хувьцаанд 88 төгрөгийн ногдол ашиг тооцон олгохоор тогтоож, 2023 оны цэвэр ашгийн 29.9 хувийг буюу 5,9 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлээд байгаа билээ.

Ингээд “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа эхлүүлье.

Та бүхэнд ХХХХ-ын дэгийг танилцуулъя.

| № | Хэлэлцэх асуудал                                                                                                | Хугацаа     | Хариуцах                                                           |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------------------------------------------------------------|
| 1 | Хурлын ирц бүртгэх                                                                                              | 11:00-12:00 | Тооллогын комисс                                                   |
| 2 | Хурлын ирцийг мэдээлэх                                                                                          | 12:00-12:05 | Тооллогын комиссын дарга                                           |
| 3 | Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах                                                                             | 12:05-12:10 | Хурлын дарга                                                       |
| 4 | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах                            | 12:10-12:25 | Гүйцэтгэх захирал                                                  |
| 5 | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх | 12:25-12:30 | Хурлын дарга                                                       |
| 6 | Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах                               | 12:30-12:50 | ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 7 | Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах                                                           | 12:50-13:00 | Хурлын дарга                                                       |

|    |                                                                                                         |             |                                                          |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------------------------------------------------------|
| 8  | Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийн саналыг танилцуулах                                                  | 13:00-13:10 | Гүйцэтгэх захирал                                        |
| 9  | Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах                                                                | 13:10-13:20 | Гүйцэтгэх захирал                                        |
| 10 | Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт                                                 | 13:20-13:40 | Хурлын дарга, Гүйцэтгэх захирал, ТУЗ-н хараат бус гишүүд |
| 11 | Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах                                                               | 13:40-14:00 | Хурлын дарга, Тооллогын комиссын дарга                   |
| 12 | Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах                                 | 14:00-14:30 | Тооллогын комиссын дарга                                 |
| 13 | Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах | 14:30-14:40 | Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга      |

Энэхүү дэгийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал маань явагдана.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах үндсэн 6 асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Эдгээр асуудлуудыг хэлэлцэн батална.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хурлын дарга О.Болдбаатар таньд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №1-Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулна уу хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.**

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №1: КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ**

**“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр “ЛэндМН ББСБ” ХК-ийн баг маань 2023 оны үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчид та бүхэндээ танилцуулж, тайлагнаж, дүгнүүлэх гэж байгаадаа туйлын их баяртай байна.

Өнөөдрийн хурал дээр 2023 оны үйл ажиллагаагааны тайлан болон санхүүгийн аудитлагдсан тайланг та бүхэнд танилцуулая. Эхлээд бүгдээрээ манай Маркетингийн залуусын бэлтгэсэн “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны онцлох үйл явдлуудыг дараах видеоноос харцгаая.

(2023 оны онцлох үйл явдлын талаар видео үзүүлэв)

2023 оны бизнесийн үйл ажиллагааг эхлээд танилцуулъя.

2023 оныг бид өсөлтийн жил гэж харж байна. Бид үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хамгийн өндөр багц, орлого, ашигт хүрч ажиллалаа. Энэ үр дүнгийн ард бидний чадварлаг хамт олны хичээл зүтгэл, ТУЗ-ийн оновчтой удирдлага чиглүүлэг, дээр нь Хувьцаа эзэмшигч та бүхний бидэнд хүлээлгэсэн итгэл байна гэж бид харж байна. 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар бид цоо шинэ уян хатан нөхцөлтэй, зах зээлд урьд нь байгаагүй бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлнэ гэж мэдэгдэж байсны дагуу бид 2023 онд маш амжилттай нэвтрүүлсэн. Үүний үр дүнд:

- ✓ Зээлийн багц: 76.4%-иар өсөж 71 тэрбумаас 125 тэрбумд төгрөгт хүрч ажиллалаа.
  - ✓ Орлого, ашиг: Багцын үзүүлэлтийг дагаж өссөн.
  - ✓ Ногдол ашиг: 2023 оны цэвэр ашгийн 30 хувь буюу 5.9 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 8 төгрөг ногдохоор ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны ногдол ашиг болох 1.75 төгрөгтэй харьцуулахад энэ жил 4-5 дахин өсөлттэй байна. Бид ногдол ашгийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “ҮЦТТТХТ” ТӨХХК-д байршуулж, улмаар Хувьцаа эзэмшигч та бүхний дансанд шилжүүлүүлэн олгохоор ажиллаж байна.
  - ✓ Хувьцааны ханш: Сүүлийн 1 жил гаруйн хугацаанд манай хувьцааны ханш 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2023 оны 01 сард хувьцааны ханш 30 төгрөг байсан бол 2024 оны 03 сард 65 төгрөг дээр тогтворжсон байна. Өчигдрийн байдлаар Хөрөнгийн бирж дээр хувьцааны ханш маань 71,04 төгрөг дээр хаагдсан. Бид үүнийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхнээс бидэнд ирээдүйд хүлээлгэж байгаа итгэл, хариуцлага гэж харж байна.
- Та бүхэндээ 2023 оны санхүүгийн үзүүлэлтийг хураангуйлан танилцуулъя.
- ✓ Зээлийн багц: 125 тэрбумд төгрөг, өсөлт 76.4%, ББСБ-н салбарын дундаж 20-30% өсөлттэй байдаг бөгөөд үүнээс даруй 2 дахин өсөлттэй ажилласан байна.
  - ✓ Хүүгийн орлого, цэвэр ашиг: 47.8 тэрбум, ашигт ажиллагаа 19.8 тэрбум цэвэр ашигтай байна.
  - ✓ Зээлийн тоо: 996.3 сая ширхэг зээлийг дижиталаар олгож ажилласан. Өдөрт хуваавал, нэг өдөрт 9,000-10,000 ширхэг зээл, ажлын нэг цагт 1,000-1,200 ширхэг зээлийг автоматаар шалгаж, автоматаар олгосон байна. Хэрэв уламжлалтаар нэг салбар өдөрт 5-10 зээл гаргадаг гэж үзвэл бид энэхүү зээлийг 100-200 салбартайгаар явуулах байсан бөгөөд технологийг нэвтрүүлсний ач холбогдол маань үүн дээр харагдаж байна.
  - ✓ Чанаргүй зээл: Манай авлагын баг 2023 онд 15-20 хүнтэй ажилласан бөгөөд чанаргүй зээлийн багц 4.1% байна. Салбарын чанаргүй зээлийн үзүүлэлт 7.5 орчим хувьтай байгаатай харьцуулахад 2 дахин баг үзүүлэлт байна.

Дээрх санхүүгийн болон бусад тоон үзүүлэлтүүдийг хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар хянана баталгаажуулсан санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулъя.

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН:

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хөндлөнгийн хараат бус аудитын компани болох “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК аудит хийж ажилласан бөгөөд энэхүү тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу тайлагнасан байна гэж хөндлөнгийн хараат бус аудитор дүгнэсэн байна. Та бүхэн аудитлагдсан дэлгэрэнгүй тайлантай [www.lend.mn](http://www.lend.mn) гэсэн компанийн албан ёсны веб хуудсаар орж танилцах боломжтой.

Энэ тайлан дээр харагдаж байгаачлан нийт хөрөнгө 133.4 тэрбум, үүнээс эздийн өмч 42.7 тэрбум ашиг 19.8 тэрбум төгрөг байна.

Ингээд танилцуулах асуудал №1 маань үүгээр дуусаж байна, та бүхэн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайлантай холбоотой сонирхсон асуултаа хурлын асуулт, хариултын хэсэгт дэлгэрэнгүй асуух боломжтой.

Та бүхэнд баярлалаа.

#### **ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №2 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зовлолийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлын тухай хэлэлцэнэ.** Та бүхнийхээ өмнө Хурлын дарга О.Болдбаатар захирлыг урьж байна.

#### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №2: КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ**

##### **ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:**

Та бүхэн дэлгэцээс харж байгаачлан ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцсан. ТУЗ-ийн зүгээс Компанийн 2023 оны үйл ажиллагааг “Хангалттай” хэмээн дүгнэж, 24/02 тоот тогтоолыг гаргасан байна. Мөн санхүүгийн аудитлагдсан тайлангийн хувьд ямарваа нэг материаллаг зөрчил илрээгүй, Монгол Улсын болон олон улсын тайлагналын стандартын дагуу тайлан маань бэлтгэгдсэн байгаа. Иймд, ТУЗ-ийн зүгээс 24/08 тоот тогтоолоор аудитлагдсан тайланг хүлээн зөвшөөрсөн болно.

Компанийн 2023 оны тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК хараат бус аудит хийж ажилласан. Мөн энэ жилийн хувьд ч бид өмнөх жилтэй адилаар олон улсын хамгийн шилдэг аудитын компани болох “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг нэмэлтээр ажиллуулж, компанийн 2023 оны санхүүгийн тайланг давхар баталгаажуулсан.

Хараат бус аудитын байгууллагуудын дүгнэлтүүд хооронд ямар нэгэн зөрүү гараагүй болохыг цохон тэмдэглэмээр байна.

Иймд өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Хувьцаа эзэмшигч та бүхнээс хүсэж байна.

Баярлалаа.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулсан Хурлын дарга О.Болдбаатартаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №3 Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг** танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны гишүүн С.Боргил таныг урья.

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №3: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны гишүүн С.Боргил:**

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

**1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулья.**

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгыг хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодтой.

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Компанийн ТУЗ нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдан нийт 35 тогтоол гаргажээ. ТУЗ-өөс гарсан бүх тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

2023 онд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс холбоотой талтай хийсэн нийт 6 сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

Энэхүү хэлцлүүд нь холбоотой талаас санхүүжилт хүлээн авах, нээлттэй гаргасан 9 тэрбумын төгрөгийн үнийн дүн бүхий бондод толгой компаниас барьцаа хөрөнгө гаргуулахтай холбоотой байсан.

**2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг танилцуулья.**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:**

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн

аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хийсэн гэрээний дүн 247.8 сая төгрөг байна.

**Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо:**

Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

**Эрсдэлийн удирдлагын хороо:**

Эрсдэлийн удирдлагын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ноцол байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бис даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болно.

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 2023 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг баталсан бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ нь үйл ажиллагаа явуулсан байна. ТУЗ-ийн гишүүдэд нэмэлт урамшуулал, шагнал, аливаа нөхөн олговор олгоогүй болно.

Та бүхэнд баярлалаа.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны гишүүн С.Боргил танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №4 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулна уу** хэмээн ТУЗ-ийн дарга, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатарыг урьж байна.

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №4: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ЭСЭХ;**

**ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:**

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн нийт гишүүдийг улируулан сонгож ажилласан билээ. Энэ жилийн хувьд компанийн үйл

ажиллагааны өсөлт, “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлж буйтай холбогдуулан энэ чиглэлийн мэдлэг, туршлага бүхий гишүүдийг ТУЗ-д байлгах үүднээс нээлттэй сонгон шалгаруулалт явуулсан. Нийт дэвшиж буй гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороогоор хэлэлцэж Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3-т заасан компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг бүрэн хангасан гэж дүгнэсэн. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид нь ёс зүйн өндөр төлөвшилтэй, эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн мэдлэг боловсрол хангалттай эзэмшсэн, бизнесийн салбарт амжилттай мэргэшиж байгаагаа баталж чадсан хүмүүс байгаа юм.

Ингээд та бүхэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дараах бичлэгээс үзнэ үү.

*(Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулга видео үзүүлэв)*

#### **ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулгатай танилцлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №5 Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийн саналыг танилцуулна уу** хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

#### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №5: ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ;**

##### **“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид та бүхэндээ Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийн санал танилцуулж байна. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, нэмээд нарийн бичгийн дарга гээд нийт 10 орон тоотой ажиллаж байна. Манай ТУЗ-ийн төсөвт 2020 оноос өнөөдрийг хүртэл огт өөрчлөлт орж байгаагүй бөгөөд энэ жилийн хувьд бид инфляц болон Компанийн үйл ажиллагаа тэлж буйтай холбогдуулан ТУЗ-ийн үйл ажиллагаа ч мөн нэмэгдэж буйг харгалзан ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг өмнөх жилүүдээс 30%-иар нэмэгдүүлсэн.

ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний хувьд ТУЗ-ийн дарга 1,950,000 төгрөг, ТУЗ-ийн дэргэдэх хорооны дарга 1,560,000 төгрөг, ТУЗ-ийн гишүүн 1,300,000 төгрөг, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга 650,000 төгрөгийн сарын цалинтай ажиллах юм.

Хурал болон бусад зардалд 10 сая төгрөг зарцуулагдахаар төсөвлөгдсөн байна. Энэ зардлын хувьд ямар нэгэн өөрчлөлт ороогүй, хуучин хэвээр байгаа.

Ингээд тооцоход ТУЗ-ийн 2024 оны нийт төсөв нь 196 сая төгрөг байна.

Иймд Хувьцаа эзэмшигч та бүхнийг ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсэж байна.

#### **ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийн саналыг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Үргэлжлүүлэн **Хэлэлцэх асуудал №6 Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг** танилцуулна уу хэмээн хүсье.

#### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №6: КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ**

### **“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:**

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг танилцуулъя.**

Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 24/11 тоот тогтоолын дагуу Компанийн дүрэмд дараах 2 агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналыг гаргасан байна. Үүнд:

Нэгдүгээрт, Компанийн дүрмийн 2.2 дахь хэсэгт заасан компанийн албан ёсны хаягийн өөрчлөлтийг оруулах саналын тухайд

- 2024 оны 02 дугаар сараас эхлэн Компанийн удирдлага болон алба, хэлтсүүд нь өөрчлөлт оруулж буй “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж-4, “Нью Хоризонс” барилга, 5 давхар, 503 тоот” хаягт нүүж ирэн, компанийн үйл ажиллагааг чиглүүлэн явуулж байна. Уг шинэ хаягийг бид СЗХ-ны журмын шаардлагын дагуу Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Гэхдээ харилцагчийн үйлчилгээний хэсэг буюу гэрээ байгуулдаг хэсэг маань хуучин хаяг буюу “Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сүвд төв, 1 тоот” хаягт хэвээр байршиж байгаа, тэгэхээр зарчмын хувьд бид уг хаягийг салбар, төлөөлөгчийн газраар бүртгүүлэн компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, тус дүрмийг СЗХ-ны холбогдох журмуудын дагуу бүртгүүлэх шаардлага үүссэн юм.

Иймд компанийн албан ёсны хаягийг өөрчилж, хуучин хаягийг салбар, төлөөлөгчийн газраар бүртгүүлэх эрхийг олгож өгнө үү гэдгийг Хувьцаа эзэмшигч та бүхнээс хүсэж байна.

Хоёрдугаарт, Компанийн дүрмийн 4.2.9 дэх хэсэгт заасан компанийн үйл ажиллагааны чиглэлд дараах үйл ажиллагааны чиглэлийг нэмэх саналын тухайд

- Компанийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24/01 тоот тогтоолоор Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” үйл ажиллагааны чиглэлийг нэмэхээр шийдвэрлэсэн бөгөөд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.6 дахь заалтанд “Компанийн дүрэмд компанийн үйл ажиллагааны чиглэлийг заавал тусгана” гэж заасан шаардлага байдаг. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд СЗХ-оос заавал байлгах нөөцийн хэмжээнээс давсан мөнгөн хөрөнгийн нөөцийн хэмжээнээс давсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэрүүд нөөцөнд байж байдаг. Энэ тохиолдолд бид мөнгөн хөрөнгөө богино хугацаанд илүү үр ашигтай удирдаж, орлого, ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” зөвшөөрлийг СЗХ-оос хүсэхээр төлөвлөж байна. Компанийн зүгээс хөрөнгө оруулалт хийхдээ ТУЗ-өөс батласан журмын дагуу 100 сая төгрөгөөс дээш бүх хөрөнгө оруулалтыг ТУЗ-руу танилцуулж, ТУЗ зөвшөөрсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэх байгаа. Илүү гарсан мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдахын тулд бид нар 1-3 сарын хугацаатайгаар Хөрөнгийн биржид нилээд идэвхтэй арилжаалагддаг компанийн бондуудыг худалдан авч, мөнгөн хөрөнгийг үр ашигтай байдлыг хангаж ажиллахаар зорьж байна.

Иймд Хувьцаа эзэмшигч та бүхэн маань “ЛэндМН ББСБ” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг нэмж Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн батлаж өгнө үү.

Дээрх танилцуулсан 2 агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулах эсэх асуудалд Хувьцаа эзэмшигч та бүхнийг идэвхтэй саналаа өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

### **ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын** хэсэг эхэлж байна. Та бүхэн гараа өргөөд чөлөөтэй асуулт асууж, хариултаа авах боломжтой. Мөн санал хураалтын цахим системээр ирүүлсэн асуултуудыг асуух болно.

Ингээд индэрт “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар, ТУЗ-н Хараат бус гишүүн С.Боргил, Компанийн Гүйцэтгэх захирал

Ц.Ууганбаяр, Компанийн Дэд захирал Д.Баасандорж, Компанийн Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор нарыг урьж байна.

Та бүхэн өнөөдрийн хуралд оролцож байгаа албан тушаалтнуудаа хүссэн асуултаа, чөлөөтэй асуух боломжтой. Зааланд манай зохион байгуулагчид микрофоноо асуулт асуух хүмүүс рүү шилжүүлээд өгөөрэй.

## **АСУУЛТ/ХАРИУЛТЫН ХЭСЭГ:**

### **Асуулт 1: Flexi зээлийн талаар дэлгэрэнгүй танилцуулж өгнө үү?**

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭЭХ-аар бид цоо шинэ Flexi зээлийн бүтээгдэхүүний танилцуулж байсан. Түүнээс хойш бид өөрсдийн 210 мянга гаруй гэрээт харилцагч дотроо үе шаттайгаар уг бүтээгдэхүүнийг нээж байгаа. Үнийн дүн нь 50 сая хүртэлх, сар болгоны эргэн төлөлт нь бусад 2-3 жилийн хугацаатай банк, ББСБ-уудын зээлтэй харьцуулахад уян хатан нөхцөлтэй, харилцагч хүссэн үедээ зээлээ аваад хүссэн үедээ хаагаад, эргүүлж авах боломжтой банкны кредит карт шиг бүтээгдэхүүн байгаа. Одоогийн байдлаар бид 20 мянга орчим харилцагчийг уг бүтээгдэхүүн рүү оруулсан байгаа, ирэх оны төлөвлөгөөнөөс энэ бүтээгдэхүүний харилцагчийн тоогоо нэмж, зээлийн багцын ихэнхийг Flexi зээлийн бүтээгдэхүүнээр бүрдүүлэхээр ажиллаж байна.

### **Асуулт 2: Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд ямар ямар санхүүгийн бүтээгдэхүүн хамаарч байгаа вэ?**

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** Одоогоор бид бодлогын хүрээнд Хөрөнгийн зах зээл дээр идэвхтэй арилжаалагддаг компанийн бондууд гэж төсөөлж байна. 1-2 сарын хугацаатай бэлэн мөнгөний илүүдэл дүн байгаа бол тэрийг компанийн бонд руу оруулаад хэрэгцээтэй үедээ буцаагаад Хөрөнгийн бирж дээр зарж, бэлэн мөнгө болгох боломжтой хөрвөх чадвар сайтай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна гэж зорьж байна.

### **Асуулт 3: Хувьцаагаа халааслах уу? 2024 оны хүүгийн орлого, цэвэр ашгийн төлөвлөгөө ямар байгаа вэ?**

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** Бид 2020, 2021 онуудад холбогдох хууль тогтоомжид заасныг үндэслэн 2 удаа хувьцаагаа халаасалж байсан. Одоогоор хувьцаа халааслах бодлого, шийдвэр байхгүй байна.

**Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:** 2024 оны зорилт, төсвөө батлаад явж байгаа, гэхдээ төсвөөр баталсан төлөвлөгөөг бид олон нийтэд нээлттэй зарладаггүй, гэхдээ хувиараа хүрч ирээд асуувал хэлж болно. 2022 оны хувьд 5.9 тэрбум байсан цэвэр ашиг 2023 онд 19.8 болсон байгаа, энэ өсөлт 2024 онд өсөөд явна, гэхдээ 5.9-19.8 тэрбум болсон шиг өсөхгүй, зээлийн багцын өсөлт өмнөх жилүүдэд 40-100 тэрбум руу явж байсан шиг 2 дахин өсөхгүй гэхдээ цэвэр ашиг нэлээд сайн байхаар төлөвлөгдсөн байгаа.

Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх дээр ТУЗ-өөс шийдвэр гарвал хөрөнгө оруулалт хийгээд явж байгаа. ТУЗ хэрвээ шийдвэр гаргасан бол тухайн шийдвэр олон нийтэд нээлттэй танилцуулагдаад явна.

**Асуулт 4: 2024 онд бонд болон ХБҮЦ хэдий хэмжээгээр гаргах төлөвлөгөөтэй байгаа вэ? Толгой компаниас авсан зээлийн хүүг хэлж болох уу? Охин компанийг 100 хувь эзэмших үү?**

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** 2024 онд бид ТУЗ-өөр батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу зээлийн багцын өсөлтийг бонд, итгэлцэл, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл гэх 3 хэрэгслээр эх үүсвэрийг хангахаар ажиллаж байна. Бондын хувьд энэ жил нээлттэй биш ОТС буюу хаалттай хүрээнд нийтдээ 20 орчим тэрбум төгрөгийн бондыг энэ жил татан төвлөрүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Өнгөрсөн жилийн сүүл, энэ жилийн эхээр ОТС бонд дээр бид анх удаа хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад бондыг санал болгож, 5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байгаа. Үүний сүүлийн транч буюу 2 тэрбумыг блокчэйн дээр буюу төлбөр тооцоо нь тэр даруй гүйцэтгэх боломжтой технологиор дамжуулж, бондыг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагч нараас татсан байгаа. Энэ жил нээлттэй ХБҮЦ, нээлттэй бонд гэхгүйгээр хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагч нараас бондыг татан төвлөрүүлэхийг зорьж байна.

Толгой компанитай хийсэн аливаа ажил үйлчилгээ сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж үздэг тул ТУЗ-ийн хараат бус гишүүд маань санал өгөх эрхтэй байдаг. Хараат бус гишүүдийн өгсөн санал, гарсан шийдвэрийг бид Хөрөнгийн биржийн веб сайтад цаг тухайд нь нээлттэй тайлагнаж, нийтэд мэдээлж байгаа. Ямар ч хамаарал бүхий этгээдтэй хийсэн ажил, гүйлгээ зах зээлийн зарчмаар явагдах ёстой байдаг, төгрөгийн хүүгийн хувьд бодлогын хүү+6 гэсэн хувь буюу бодлогын хүү 13%-тай байхад бид нар 19% нар толгой компаниас татж бийш. Дэлгэрэнгүй толгой компанитай хийж байгаа бүх мэдээллийг Хөрөнгийн бирж дээр тавигдсан мэдээллээс харж болно.

**Асуулт 5: Үйл ажиллагаа дээр зээлийн үйл ажиллагаанаас гадна шинэ үйл ажиллагаа нэмэх үү?**

**Хариулт, Дэд захирал захирал Д.Баасандорж:** ЛэндМН-ийн хувьд бид 2018 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байхдаа финтекийн маш олон салбаруудтай байсан, сүүлийн 2 жил менежментийн зүгээс илүү нарийвчилсан бүтээгдэхүүнүүд дээр фокуслан ажиллаж байна. Яг одоо бол зээлийн үйлчилгээн дээр нэмэлт шинэ үйл ажиллагаа эрхэлнэ гэсэн төлөвлөгөө одоогоор байхгүй байна. Хэрвээ тийм шийдвэр гарвал Удирдлагын багаар хэлэлцэж байгаад шийдвэрлэнэ.

**Асуулт 6: ЛэндМН-ийн цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар танилцуулж өгнө үү?**

**Хариулт, Дэд захирал захирал Д.Баасандорж:** Цаашаа үйл ажиллагаагаа тэлж байгаа ажлууд бид нар хийгээд явж байгаа, бүр нарийвчлан яривал, манай нийгэм эдийн засгийн суурийг бүрдүүлж байгаа SME буюу бичил бизнес (жижиг дунд бизнес биш)-үүдийн сегмент дээр төвлөрсөн маш их судалгааны ажлууд хийгдэж байна. Манай зүгээс бүтээгдэхүүнээ гаргачихсан, бичил бизнесийн зээл дээр ЛэндМН цаашид буюу энэ жил, тэрний дараагийн жил ч анхаарч ажиллахаар байна. Энгийн хэрэглээний зээлээ хаяна гэсэн үг огт биш, илүү бизнес маань тэлж байгаа юм. Асуулт хариултын дараа жижиг персентаци танилцуулахад дэлгэрэнгүй сонсож болно.

**Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор:** Бид нар энэ жил бүтээгдэхүүнээ өрхийн бизнес эрхэлж байгаа, тэр зах зээлд ажиллаж байгаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахаар зориод эхний ажлуудаа хийгээд явж байна. Одоогийн байдлаар банкнуудаас өөрийнхөө бизнесийг батлаад бизнесийн зээл аваад, бизнесээ өргөжүүлээд явж байгаа хүмүүс байгаа, гэхдээ банканд бизнесээ баталж чадахгүй байгаа, өөрийнхөө бизнесийн орлого, ашгийг тодорхойлж чадахгүй байгаа тэр зах зээлийг бид илүү сонгож, бизнесийн хэрэгцээ

шаардлага, барьцаа хөрөнгийн асуудал, банк руу удаан хугацаанд зээлийн судалгаа шинжилгээ хийлгэх, 4-5 хоногийн хугацаанд хөөцөлдөж явах боломжгүй байгаа тийм хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онлайнаар гар утсаар, аппликейшнээ ашиглаад яаж шийдвэрлэж болох вэ гэдэг дээр илүү анхаарч, анхны бүтээгдэхүүнээ 2024 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс нийт бизнес эрхлэгч нартаа санал болгоод явж байна. Энэ ондоо бид энэ зах зээл дээр бүтээгдэхүүнээ яаж төрөлжүүлж, өөр шинэлэг нөхцөлүүдийг санал болгох вэ гэдэгтээ анхаарч ажиллаж байна. SME зээлдэгч нарын хувьд зөвхөн санхүүгийн зээлийн үйл ажиллагаа гэхээсээ илүү бизнес эрхлэгч нар маань данс хөтлөлт, санхүүгийн ойлголт, мэдлэг, сургалт гээд маш олон зүйлс хэрэгтэй болдог, ЛэнлМН нь зөвхөн санхүүжилт өгөөд зогсдог гэдгээсээ илүү тэд нарыгаа сургах, дараа дараагийн зээлийн үйл ажиллагаанд нь бэлтгэх, санхүүгээ хэрхэн оновчтой явуулах уу гэдэгт анхаарч ажиллаж байна.

#### **Асуулт 7: Танай зээлийн хүү буурах уу?**

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** Бид өөрсдийн бүтээгдэхүүний хүүг тодорхойлохдоо хэд хэдэн нөхцөлүүдийг харгалзаж үздэг. Хамгийн түрүүнд бүтээгдэхүүний хүүгийн өрсөлдөх чадварыг харна. Энэ нь нэг салбарт ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа финтек, барьцаагүй зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа бүтээгдэхүүнтэй харьцуулахад манай зээлийн хүү өндөр байна уу, бага байна уу, өрсөлдөхүйц байна уу гэдгийг тогтмол манай бүтээгдэхүүний алба хийж байгаа. Хамгийн сүүлийн судалгаагаар бол манай зээлийн хүү барьцаагүй зээлийн бүтээгдэхүүний хувьд боломжийн, бусад байгууллагуудтай харьцуулахад дундаж байна гэсэн дүгнэлт гарсан. Зээлийг хүүг тодорхойлж байгаа ганц том хүчин зүйл байлаг нь эх үүсвэрийг өртөг, 2020 оноос хойш Монгол банкнаас бодлогын хүүг 6-13 хүртэл буюу 2 жилийн дотор 2 дахин өсгөсөн, энэ оны 3 сард Монгол банкнаас бодлогын хүүг 1 хувь бууруулж байна. Энэ он сонгуулийн жил, инфляцын дарамт байна гэж харж байгаа учраас цаашдаа Монгол банкнаас бодлогын хүүгээ бууруулахгүй байх гэсэн шинжээчдийн дүгнэлт, таамаг байгаа. Бодлогын хүү буурахгүй үед эх үүсвэрийн өртөг ойрын хугацаандаа буурахгүй, тэгэхээр бид цаашдаа хүүгээ бууруулах айхтар бодол байхгүй байна. Гэхдээ сая гаргаж байгаа жижиг өрхийн бизнесийг дэмжсэн бүтээгдэхүүн дээрээ тулгуурлаад гаднаас хямд эх үүсвэртэй урт хугацаатай санхүүжилтийг татах гээд сүүлийн 7-8 сар ажиллаж байна. 2-3 байгууллагатай гэрээ хэлэлцээрийнхээ шатанд явж байна. Тэр санхүүжилт маань ороод ирэхээр жижиг, өрхийн бизнес эрхлэгч нартаа олгож байгаа зээлийн хүүг хамгийн бага хэмжээнд барихыг зорьж ажиллаж байна.

#### **Асуулт 8: Дэлхий өөрөө байгаль орчноо хайрлая гэдэг рүү явчихсан тул энэ төрлийн төлөвлөгөө санхүүжилт ямар явцтай явж байгаа вэ?**

**Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор:** Сүүлийн үед ихээр яригдаж байгаа ногоон зээлийн талаар ярья. Яагаад ногоон зээл гэдэг зүйлийг дэлхий ярих ёстой байгаа вэ гэдэг рүү орж байна. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн үед та бид ч гэсэн байгаль, цаг уурын янз бүрийн өөрчлөлтөд ороод бизнес, эдийн засаг, амьдралд олон байдлаар нөлөөлж байгаа. Хүмүүсийн бизнесийн үйл ажиллагааны хэрэглээг яаж байгальдаа ээлтэй болгох вэ гэдэг дээр бүх л дэлхий ажиллаж байгаа гэсэн үг. Санхүүгийн байгууллагаар дамжуулаад хүмүүсийн хэрэглээг эко болгоно гэдэг маань энэ байгаль орчин, цаг уурын өөрчлөлттэй тэмцэх хамгийн хурдан хүрч болох зам юмаа гэж олон улс бүгд тодорхойлчихсон байгаа юм. Тийм учраас сүүлийн үед банк, санхүүгийн байгууллагууд илүү ногоон бүтээгдэхүүн гаргая, хүмүүсийн хэрэглээг ногоон болгоё гэдэгт зорьж ажиллаж байна. Бидний хамгийн сайн мэдэж байгаа нь банкнууд хэрэглээний ногоон зээл дээр илүү ажилласан. Дулаалга, эко автомашин, орон сууц, дугуй, скүүтер зэрэг хүний хэрэглээг яаж эко болгох вэ гэдэг дээр ажиллаж байгаа. Манай ЛэндМН-ийн хувьд мөн эко автомашины зээлийг гаргаад явж байна. Энэ жилээс бизнесийн зээлийг олгож

эхлэхтэй холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаандаа эрчим хүчний хэмнэлтийг бий болгож байгаа, тэрэндээ шинэ техник, технологи оруулж ирж байгаа тэр бизнесүүд дээр хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргана гэж харж байна. Аливаа зүйл өөр өөрөөсөө эхлэх ёстой учир ЛэндМН тэр ногоон зээлийг гаргахаасаа эхлээд өөрийн дотоод үйл ажиллагаанд яаж эрчим хүчний хэмнэлтийг хийж болох уу, өөрийн аппликейшнд яаж тэрийг тусгаж болох уу гээд маш жижиг зүйлсээс эхэлж байгаа гэж хэлж болно. Шинэ апп дээрээ бид дэлгэцийн суурь өнгийг хар өнгөтэй болгож байгаа, энэ маань дэлгэцийн цахилгаан зарцуулалт, эрчим хүч хэмнэх боломжтой жижиг боловч олон хүн хэрэглээд эхэлбэл үр нөлөөгөө өгөх боломжтой зүйлүүдээс бид эхэлж байгаа. Цаашид бол жижиг, өрхийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаан дээрээ эко, эрчим хүчний хэмнэлт хийх гэж байгаа тэр бүх бизнесүүдийг бид дэмжинэ, тэрэнд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахаар зорьж байна.

**Асуулт 9: Lendpay бүтээгдэхүүн чинь одоо аваад, дараа төл гэдэг концепцтой байгаа, энэ бүтээгдэхүүн салбарынхаа хэдэн хувийг эзэлж байна вэ, Storepay, Pocket, Sono зэрэг компаниудтай хэрхэн өрсөлдөх вэ?**

**Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор:** Энэ төрлийн бүтээгдэхүүнээс Монголын зах зээл дээр хамгийн сайн танигдсан нь Storepay, Pocket байна, одоо банкууд ч мөн гаргаж ирж байна. Lendpay бүтээгдэхүүнийг гаргаж ирж байгаа шалтгаан нь харилцагчдаа зээлийн бүтээгдэхүүнийг илүү олон сонголттой ашиглуулах зорилгоор гаргаж байгаа, бидний зах зээлд эхлэх хувь одоогоор бага байгаа, харилцагч маань хүүтэй гэхээс илүү хүүгүй бүтээгдэхүүнийг ашиглаасай гэсэн нэмэлт сонголт гэж харж байгаа. Бидний хувьд өрсөлдөгч нараасаа ялгарч байгаа онцлог нь BNPL бүтээгдэхүүнийг харахаар 4, 6 хувааж төлөөд тухайн зээлийн хугацаа байдаггүй, тэгээд дуусдаг гэсэн үг. Манай BNPL-н ялгарч байгаа онцлог нь зээлийн хугацаа дуусаж байгаа боловч зээлдэгч маань төлөх боломжгүй бол эргүүлээд энгийн зээл рүүтээ шилжүүлдэг онцлогтой байгаа. Энэ дээр хэрэглэгч манай бүтээгдэхүүнийг хэрэглээд эхлэхээрээ бүтээгдэхүүний онцлогийг ойлгоод, цаашдаа хэрэглээ нэмэгдэнэ.

**Асуулт 10: Зээлийн барьцаагүй аппууд их байна, цаашид өрсөлдөгч нартайгаа хэрхэн өрсөлдөх вэ? Монгол банкнаас хэрэглээний зээлийг хумина гэсэн энэ нь зээлийн багцыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү? Барьцаагүй зээлийн зах зээлийн хэдэн хувийг одоогоор ЛэндМН эзэлж байгаа вэ?**

**Хариулт, Дэд захирал захирал Д.Баасандорж:** Өрсөлдөөний хэсэг дээр бид санаа зовдоггүй, учир нь финтекийн зах зээлд бид харилцагчийнхаа тоогоор 2-р байранд байгаа байгууллагаасаа бараг 2 дахин их харилцагчтай, номер 1-т байгаа. Зээлийн багцын хувьд бүтэн дата мэдээлэл байдаггүй ба бидний тооцоогоор бол бид топ 5-даа орж байгаа. Нөгөө талаас томоор харвал 2022 оны гэхэд нийт ББСБ-ын зах зээл 3.5 их наяд буюу тухайн үеийн долларын ханшаар 1 тэрбум доллар байсан, 2023 он дуусч байхад нийт ББСБ-ын зах зээл 4.2 их наяд буюу одоогийн долларын ханшаар бодвол 1 тэрбум доллар гараад явчихсан байгаа. Өсөлт маань жил болгон ББСБ-н зах зээл 31-35%-иар өсдөг, Монгол улсын санхүүгийн сектор 90% нь банк, 8% нь ББСБ дээр байдаг. Нийт 4.2 их наяд эргэлддэг ББСБ-ын зах зээлд бид 125 тэрбумтай байна гэдэг маш бага зах зээлийг эзэлж байгаа гэж ойлгож болно. Нийтдээ 531 ББСБ, 32 финтек байдаг. 32 финтек дотроо бол бид топ 3-таа ордог гэж хэлж болно.

Хэрэглээний зээлийн Монгол банкнаас гаргасан журам буюу хугацааг 30, 96 сар дээр аваачсан байгаа. Монгол банкнаас хэрэглээний зээлийг хязгаарлаж байгаа гэдэг нь банкуудаас хязгаарлаж байгаа гэж ойлгож байна. Хэрэглээний зээлийн хугацааг 30 сар дээр барьсан нь ББСБ-г хөгжих гол фактор болсон байдаг. Энэ нь нөгөө талаасаа банкуудыг барууны, өндөр хөгжилтэй орнуудын

модель руу шилжүүлэх гэж байгаа юм байна гэж харж байгаа. Өндөр хөгжилтэй орнуудад банкнууд нь 500 мянган төгрөгийн жижиг зээлүүдийг гаргаад байдаггүй, ихэвчлэн финтекүүд нь олгодог, нөгөө талаас харилцагч нар нь ч гэсэн тэднээсээ авах илүү сонирхолтой байдаг. Монгол банкнаас хэрэглээний зээлийг хязгаарлаж байгаа нь бидэнд олгож байгаа боломж гэж харж байна.

**Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор:** Нэмээд хэлэхэд “Хэрэглээний зээлийг чангаруулна гэдэг” нь өнгөрсөн оны сүүлээс яриад явж байгаа, Монгол банкнаас ч хэрэглээний зээлийг аль болох хумиад, бизнесийн зээлийн тэлэлт дээр дэмжиж ажиллана гэдэг мэдэгдлүүд хийгээд явж байгаа. Гэхдээ хэрэглээний зээлийг чангаруулна гэдэг бол өр, орлогын тооцох журмыг чангаруулж байж энэ нөлөөлнө, гэхдээ одоогийн байдлаар өөрчлөлт ороогүй байгаа. Банкнуудын гарч байгаа зээлийг бизнесийн зээл рүү гаргах хөшүүрэг гэж харж байна. Бидний хувьд бол хүчтэй нөлөөлөл орж ирэхгүй байх төсөөлөл байна.

Барьцаагүй зээлийн хувьд бизнесийн зээлийг барьцаагүйгээр дижиталаар шийдэж чадсан хамгийн анхны байгууллага гэж ам бардам хэлж чадна. Хэрэглээний зээл дээр бол олон өрсөлдөгч нар байгаа, бизнесийн зээлийн хувьд бид дижитал зах зээл дээр цор ганцаар эхэлж байна.

**Асуулт 12: Ногдол ашгийн бодлого 2022 онд 23.4 хувь байсан, энэ жил 29.4 хувь болж нэмэгдсэн байна, цаашид нэмэгдээд явах уу, энэ ногдол ашгийн бодлого маань компанийн дүрэмд суусан уу эсвэл тухайн жилдээ ТУЗ шийдээд явж байна уу?**

**Хариулт, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:** Жил болгоны ногдол ашгийг ТУЗ-оос тухай бүр санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, компанийн бэлэн мөнгөний үлдэгдэл зэргийг харгалзан шийдээд явж байна. Анх IPO хийхэд эхний 3 жилдээ цэвэр ашгийнхаа 30 хүртэлх хувийг заавал ногдол ашигт хуваарилна гэсэн амлалтыг өгч байсан, тус 3 жилийн хугацаа бол өнгөрчихсөн. Тэрнээс хойших ногдол ашгийг ТУЗ тухай бүр шийдээд явж байна, Компанийн дүрэмд ногдол ашиг заавал хуваарилна, тэдэн хувьд барина гэсэн зүйл байхгүй. Монголын хөрөнгийн зах зээлд компаниудыг тарааж байгаа ногдол ашгаар нь дүгнээд байгаа, уг нь бол зөв үзүүлэлт биш. Компани 30-40%-ийн өсөлт үзүүлэлт үзүүлсэн байхад ногдол ашиг тараахгүйгээр тухайн эх үүсвэрээ компани өөртөө үлдээгээд үйл ажиллагаандаа зарцуулж байх юм бол компани илүү хурдан тэлэх ёстой, гэхдээ бид бол ногдол ашгийг жил болгон тараагаад ирчихсэн байгаа, зах зээл дээр мөн ийм хүлээлт байдаг тул тэр жишгийг дагаад явж байна.

**Асуулт 13: Гадагшаа гарах сонирхол байгаа юу? “Инвескор” ХК дундад Азийн зах зээл рүү гарчихлаа. Зүүн өмнөд Ази руу гарах уу? Япон хүн байгаа юм чинь зөрүүлээд Япон, Тайланд руу гарах уу? Энэ тал дээр ямар нэгэн бодлого байгаа юу?**

**Хариулт, Дэд захирал захирал Д.Баасандорж:** Манай Монголын ББСБ, банк, компаниуд гадаад зах зээл рүү үйл ажиллагаа явуулж байгаад бид бүхэн баяртай байдаг. Бид Филиппинд бол бизнестэй, тэр маань Зүүн Өмнөд Азийн 120 сая хүн амтай зах зээлд Монгол компани 2 байгаагийн нэг нь манайх байгаа. Бидний зүгээс ямар бодлого баримтлаж байгаа вэ гэхээр санхүүгийн бизнесээ авч яваад тэрийгээ өөр улсад нутагшуулаад хийнэ гэдэг нь хэцүү юм биш үү гэсэн дүгнэлт байгаа. Гэхдээ манай толгой компанид “Анд сольюшн” ХХК гэж байгаа, энэ “Анд сольюшн” ХХК нь Зүүн Өмнөд Азийн 12 улсад 25 харилцагчтай, ЛэндМН-д ашиглаж байгаа технологиуд дээр суурилсан ноу-хаутай, тийм технологийн бүтээгдэхүүнүүдийг зараад явдаг. Тэр нь Толгой компанийн зүгээс хамаагүй ирээдүйтэй, илүү далайцтай гэж харж байгаа. 2021 оноос хойш бид 12 улсад 25 харилцагчтай байна гэдэг нь Монголд байхгүй компани байгаа. Бид технологио гадаад руу гаргах нь илүү үр дүнтэй, бүр том зах зээл гэж харж байгаа.

**Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:** Д.Баасандорж захирлын ярьсан зүйл дээр тодруулаад нэг зүйл хэлэхэд Филиппинд байгаа компани бол манай Толгой компани болох “Анд Глобал” ХХК-ийн зэргэлдээ оршдог охин компани байгаа, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дор үйл ажиллагаа явуулдаггүй, “ЛэндМН ББСБ” ХК бол СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа компани гэдгийг онцолъё. Бид ББСБ-ын зах зээл нь 3.2-4.5 их наядын хангалттай том, хурдацтай өсөж байгаа зах зээл гэж харж байна, энэ дотроо бид бүтээгдэхүүнээрээ, хэрэглэгчид өгч байгаа үнэ цэнээрээ ялгараад хангалттай томорч болохоор байна. ТУЗ-ийн ердийн гишүүнээр орж ирж байгаа Кацухико Мадоно нь Зүүн Өмнөд Азийн 2 улсад Хэрэглээний бичил бизнесийн зээлийн арвин их туршлагатай хүн байгаа, тэр их туршлагыг бид ЛэндМН-д нутагшуулж, энэ хүний ноу-хаут шингээсэн зах зээлд хэрэгтэй бүтээгдэхүүнийг гаргая гээд ойрын хэдэн жилдээ зорьё.

**Асуулт 14: ЛэндМН-ийн дотоод хүний нөөцтэй холбоотой мэдээллийг өгнө үү?**

**Хариулт, Хүний нөөц, соёлын албаны менежер Г.Болор-Эрдэнэ:** Одоогийн байдлаар манай ЛэндМН 97 ажилтантай, дундаж наслалт 30, 60% нь эмэгтэй, 40% нь эрэгтэй, ЛэндМН-д ажилласан дундаж хугацаа нь 2.6 жил байна. Бид гадны консалтингийн байгууллагаар жил бүр ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг хийлгэдэг. Энэ жил бид “Оноодор буюу оноодроос хойш бид илүү сайн хүнийг бүтээх, илүү сайн соёлыг бүтээх” гэдэг дээр удирдлага болон ажилтнууд бүгд оролцон ажиллаж байна.

**Асуулт 15: Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах эрх бүхий албан тушаалтан болох ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил та “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааг дүгнэж, сэтгэгдлээсээ хуваалцана уу?**

**Хариулт, ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил:** Би анх “ЛэндМН ББСБ” ХК үүсгэн байгуулагдах цагаас нь эхлэн хамтарч ажиллаж байна. 2023 оны ашиг болон ногдол ашгийг харахад ийм том өсөлттэй компани байгаа билүү энэ талаас нь харах хэрэгтэй. 2024 он ямар байхыг хэлж мэдэхгүй байна, ямар ч байсан 2023 оноос илүү байх нь тодорхой. 2023 он бол Ковидоос хойш компанийн үйл ажиллагаа идэвхжиж тус үр дүнд хүрсэн гэж харж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүн бид нар Хувьцаа эзэмшигч та бүхний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. Бид компани өөрөө хүсээд ийм шийдвэр гаргах гэж байна гэвэл тэрийг дагахгүй. Бид бүгдийн хувьд маш их асуулт тавьдаг, толгой компанитай сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулах, их хэмжээний хэлцэл хийхэд асуулт тавих үүрэгтэй юм. Үүнээс харвал бид ихэнхдээ эрсдэл талыг их хардаг. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд нэг том давуу тал нь маш олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг компани биш, Монголын зарим том компаниуд нь нэг том үйлдвэртэй, эсвэл ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг хажуудаа ББСБ-тай байдаг. Бусад ААН, салбарууд нь ББСБ-ынхаа мөнгөнийхөө эх үүсвэрийг татаад байдаг бол “ЛэндМН ББСБ” ХК-д тийм зүйл байхгүй учир яг өөрийн органик буюу байж болох нөхцөлт байдлаараа хөгжиж байгаа учраас засаглалын хувьд цэвэрхэн байна, үйл ажиллагааны хувьд бусад салбар нь татаад унагаагчидна гэсэн эрсдэл багатай байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд засаглалын хувьд хамгийн эрүүл, аятайхан компани гэж бодож байна.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын хэсэг өндөрлөлөө. Хэлэлцэж буй асуудлаар санал хураах үе шат эхэллээ.

**САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА 20 МИНУТ.**

Одоо бүгдээрээ САНАЛ ӨГӨХ ЗААВАР-тай танилцъя.  
(Хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх заавар бичлэг үзүүлэв)

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

**ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДЛУУДААР САНАЛ ХУРААЖ ДУУСЛАА.**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах хэсэг эхэлж байна. Индэрт тооллогын комиссын дарга С.Батбуянг урьж байна.

**Тооллогын комиссын дарга С.Батбуян:**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж дууслаа. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд миний бие С.Батбуян, гишүүд Г.Гэрэл, Г.Солонго, Х.Хулан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулбал:

**Нэг.**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудалд өгсөн нийт **601,879,998** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:
  - 1.1. Зөвшөөрсөн **601,879,998** ширхэг хувьцааны санал буюу **100%**;
  - 1.2. Татгалзсан **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%**;
  - 1.3. Түдгэлзсэн **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%** байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэр хүчинтэй.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:
  - 2.1. О.Болдбаатар **601,869,270** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.67%**;
  - 2.2. Ц.Ууганбаяр **603,397,536** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.71%**;
  - 2.3. Б.Хос-Эрдэнэ **602,779,817** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.69%**;
  - 2.4. Кацухико Мадоно **602,148,134** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.67%**;
  - 2.5. Ц.Одмаа **600,586,992** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.63%**;
  - 2.6. С.Энх-Амгалан **600,664,925** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.63%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:
  - 3.1. Ж.Жаргалсүрэн **601,382,014** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын **33.30%**;
  - 3.2. С.Боргил **601,990,234** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын **33.34%**;

3.3. С.Нэргүй **602,351,089** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгсөн нийт саналын **33.36%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.

4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах санал хураалтын дүн:
  - 4.1. Зөвшөөрсөн **601,876,918** ширхэг хувьцааны санал буюу **99.9995%**;  
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **100.00%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
  - 4.2. Татгалзсан **3,080** ширхэг хувьцааны санал буюу **0.0005%** (Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд **0.00%** гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
  - 4.3. Түдгэлзсэн **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%** байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэр хүчинтэй.
5. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах санал хураалтын дүн:
  - 5.1. Зөвшөөрсөн **601,879,998** ширхэг хувьцааны санал буюу **100.00%**;
  - 5.2. Татгалзсан **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%**
  - 5.3. Түдгэлзсэн **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%** байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчинтэй.

**Хоёр.** Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас байхгүй болохыг баталгаажуулсугай.

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгөх эрх бүхий нийт хувьцаа эзэмшигчдээс брокер, диллерийн компаниудаар дамжуулан урьдчилан ирүүлсэн санал гараагүй болохыг тэмдэглэсүгэй.

Ийнхүү тооллогын комиссын тогтоолыг гаргаж 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын санал хураалтын дүнг баталгаажуулж байна.

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа Эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах хэсэг эхэлж байна.

Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалтын дүнд үндэслэн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулна уу хэмээн Хурлын дарга О.Болдбаатар таныг индэрт урьж байна.

**ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:**

ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

(ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав)

**ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:**

Нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг байгууллагууд, бүх харилцагч та бүхэндээ баярлалаа. “ЛэндМН ББСБ” ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нийт 7 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2024 онд ЛэндМН-ийн хамт олон бид улам хичээн ажиллах болно.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчид, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. Дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дахин уулзацгаая. Баяртай.

**ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:**



О.БОЛДБААТАР

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга

М.ТҮВШИНЖАРГАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал,  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын дарга

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

Б.ОЮУНБОЛД

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
Нарийн бичгийн дарга